

Хүнс болон эмийн үйлдвэрийн дэргэдэх лабораторийн микробиологийн шинжээч, төгсөгч нарт зориулсан сургалт амжилттай зохион байгуулагдлаа

Үйлдвэрлэлийн Технологийн Сургуулийн Биотехнологи шим тэжээлийн салбар болон "Micro World" ХХК-ийн микробиологийн сорилт, судалгаа шинжилгээний лабораторитай хамтран **"ЛАБОРАТОРИЙН САЙН ДАДАЛ"** (MW-level:L01) микробиологийн лабораторийн интерактив сургалт хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулагдав.

Микробиологийн лабораторид ажиллах үр чадвар, шинжилгээний үр дүнг боловсруулах, лабораторийн техник ажилбар, био-аюулгүй байдлыг хангаж, микробиологийн шинжлэх ухааны бүхий л үе шатны мэдлэгийг дээшлүүлэх болон микробиологчдийн хоорондын холбоог бэхжүүлж, тасралтгүй мэдлэг солилцох нөхцөлийг бий болгоход сургалтын гол зорилго оршиж байна.

Тус сургалт 2022 оны 09-р сарын 14-16-ны хооронд болж ҮТС-ийн БШТС-ын профессор, доктор (PhD) Ц.Энхтуул "Судлаач, шинжээчийн ёс зүй" сэдвээр, ШУА, Биологийн хүрээлэн, Микробиологийн лабораторийн ЭШДэА Х.Гантуяа "Сүүн хүчлийн бактерийн судалгаа, шинжилгээ, арга зүй" сэдвээр тус тус лекц уншиж "Micro World" ХХК-ийн захирал магистр О.Бүдханд биоаюулгүй байдлын талаар ерөнхий ойлголт болон микробиологийн лабораторийн сайн дадал олгох практик, дадлагын хичээлийг "Micro World" ХХК-ийн микробиологийн судалгаа шинжилгээний лабораторит орлоо.



Энэ удаагийн сургалтын онцлог 87,5% нь эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр байсны дотор "Монос Фарм" Трейд ХХК, Мон тариур ХХК, "Цомбо Фарм" тун шилтэй тарилгын эмийн үйлдвэр, "Нахиа" эмийн үйлдвэр, "Тавин –Ус" ХХК-ийн эмийн үйлдвэр болон Атар-Өргөө хүнсний үйлдвэрийн микробиологич-шинжээчид, чанарын хяналтын албаны ахлагч нарын нийт 8 хүн оролцов. Эдгээрээс 4 нь ҮТС-ийг Хүнсний микробиологи, биотехнологи мэргэжлээр төгсөгчид байна. Сургалтыг амжилттай дүүргэсэн оролцогчдод Сертификат олгов. Энэхүү сургалт нь сургууль үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, онол практикийн үйл ажиллагааг уялдуулах, төгсөгчидтэй эргэх холбоотой хамтран ажиллахад чухал ач холбогдолтой боллоо гэж зохион байгуулагчид болон оролцогчдын зүгээс үзэж байна.

